



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/164

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумаас ирэх 5000 боодол өвсний ачаа тээврийн зардал 20,000,000 (хорин сая) төгрөг, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд Богд, Баруунбаян-Улаан, Уянга сумын Таац, Жаргалант багт хүргэсэн хүчит тэжээлийн тээврийн зардалд 6,047,500 (зургаан сая дөчин долоон мянга таван зуу) төгрөг, аймгийн нөөцөд 200 тонн тэжээлийн буулгалтын зардалд 400,000 (дөрвөн зуу мянга) төгрөгийн зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 26,447,500 (хорин зургаан сая дөрвөн зуун дөчин долоон мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн өвсний мөнгөнөөс олохоыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3.Өвс болон хүчит тэжээл тээвэрлэсэн автомашинуудтай гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100352

Аймгийн Засаг даргын 2021 оны.....  
 дугаар сарын .....-ны өдрийн ..... дүгээр  
 захирамжийн хавсралт



**ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ**

№	Арга хэмжээний нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/	Тайлбар
1.	Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумаас 5000 боодол өвсний ачаа тээврийн зардал	5000	4000	20,000,000	4 автомашин ачсан
2.	Богд суманд хүргэсэн хүчит тэжээл тээврийн зардал	226.5 тонн	15000	3,397,500	
3.	Баруунбаян-Улаан суманд хүргэсэн хүчит тэжээл тээврийн зардал	123	15000	1,845,000	
4.	Уянга сумын Таац, Жаргалант багт хүргэсэн хүчит тэжээлийн тээврийн зардал	115	7000	805,000	
5.	Аймгийн нөөцийн тэжээлийн буулгалтын зардал	200 тонн		400,000	50тонн тэжээлийг 100,000 мянган төгрөгөөр буулгуулсан
	<b>Нийт</b>			<b>26,447,500</b>	